

“ЦАХИМ САНХҮҮ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 143, 2012 оны 17 дугаар тогтоолууд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3,7-д санхүү, төсвийн үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох зорилтууд тусгагдсан.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1-д Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл нь санхүүжилтийн үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх, 31.1.2-т хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх шаардлага тавигдсан байна.

Санхүү, төсвийн мэдээллийг боловсруулах программ шинэчлэгдсэн, программыг ашиглах санхүүгийн ажилтнуудын мэдлэг дутмаг, энэ талаар сургалт огт хийгдээгүй, зарим нягтлан бодогч нар өөрчлөгдсөн.

Улс орны хөгжил хурдацтай хөгжиж буй энэ үед санхүү, төсвийн мэдээлэл үнэн зөв, ашиглах боломжтой байх, шуурхай байдлыг хангах, санхүүгийн ажилтнуудын ажлыг хөнгөвчлөх, ил тод, нээлттэй болгох шаардлага нэн чухал байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан авах цахим программ шинэчлэгдсэн, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шаардлагын дагуу санхүүгийн тайлангийн маягтууд, тайлангийн эдийн засгийн шинжилгээ хийх аргачлал өөрчлөгдсөн, байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллах шаардлага гарсан, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрүүлэх, санхүүгийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхижуулах шаардлага байна.

Аймаг, сумдын төрийн сангийн төлөөлөгч, мэргэжилтэн нарын компьютер, тоног төхөөрөмж нь ашиглалтын хугацаа дууссан, программ ашиглах хүчин чадал, үзүүлэлт нь хангалтгүй, мэдээллийг олон нийтэд хүргэх өөрийн гэсэн цахим сайт байхгүй зэрэг шийдвэрлэх олон асуудлууд байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Санхүү, төсвийн мэдээллийг богино хугацаанд боловсруулах, шинэ программыг бүрэн ашиглах, төсвийг хөтөлбөр, арга хэмжээгээр төлөвлөх, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрүүлэх, санхүүгийн ажилтнуудыг чадавхижуулах, шаардлага хангасан компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээллийг ил тод, нээлтэй мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх, санхүү бүртгэлийн стандартыг хангасан цахим үйл ажиллагаатай, ил тод, бодит мэдээлэлтэй, чадварлаг боловсон хүчинтэй санхүү, төсвийн албыг бүрдүүлэн бэхжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1.Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарын төсвийн төслийг хөтөлбөр, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээр боловсруулах сургалтыг зохион байгуулна.

3.2. Сумдын төсөвт байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх 21 агентлагийн санхүүгийн ажилтнуудад ажил төрлийн нэгдсэн семинар хийнэ.

3.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт шинэ программ ашиглах сургалт зохион байгуулна.

3.4. Аймгийн томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогч нарт Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шаардлагын дагуу санхүүгийн тайлан гаргах, эдийн засгийн шинжилгээ хийх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, мөрдөж ажиллах, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн

нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулна.

3.5. Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарыг хүчин чадал өндөртэй, шаардлага хангасан суурин компьютерээр хангана.

3.6. Аймгийн санхүү, төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох цахим сайт, мэдээллийн самбартай болно.

Дөрөв. Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Аймгийн 17 сум, 21 агентлагийн 125 хүнд “Төсвийн төслийг хөтөлбөр, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээр боловсруулах” сургалтыг 2014 оны 04 дүгээр сард зохион байгуулна.

4.2. Сумдын төсөвт байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх 21 агентлагийн санхүүгийн ажилтнуудад “Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүгийн зөрчлийг бууруулах” сэдэвт ажил төрлийн нэгдсэн семинарыг 2014 оны 4 дүгээр сард хийнэ.

4.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт Fiscal, Freebalanc, E balance программ, байгууллагын нягтлан бодогч нарт Accolus, Plastic программыг ашиглах сургалтыг мөн 2014 оны 04 дүгээр сард зохион байгуулна.

4.4. Аймгийн томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогч нарт “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шаардлагын дагуу санхүүгийн тайлан гаргах, эдийн засгийн шинжилгээ хийх, стандартыг нэвтрүүлэх” талаар сургалтыг 2014 оны 04 дүгээр сард зохион байгуулна.

4.5. Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт хүчин чадал өндөртэй, шаардлага хангасан суурин компьютерыг 2014 оны эхний хагас жилд багтаан нийлүүлнэ.

4.6. Санхүү, төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх www.sankhuu.kho.gov.mn сайтыг 2014 оны 03 дугаар сард багтаан хийж ашиглалтанд оруулна.

4.7. Санхүү, төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх “Мэдээллийн самбар” хийж аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 давхрын зааланд байршуулна.

4.8. Хөтөлбөрийг сурталчилах, хэвлэх, олшруулах, мэдээлэх, танилцуулах арга хэмжээ авна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт, тайлагналт

5.1. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр:

5.1.1. Орон нутгийн хөгжлийн сангаас

5.1.2. Аж ахуйн нэгж байгууллагаас

5.1.3. Байгууллагын төсвөөс

5.2. Хөтөлбөрийн тайлагналт:

5.2.1. Хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бүрдүүлэн нэгтгэн гаргах.

5.2.2. Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа зорилт, арга хэмжээ бүрийн заалтын биелэлтийг хүрсэн үр дүнтэй нь гаргах.

5.2.3. Хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн нэгдсэн тайланг гаргах.

5.2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн болон зарцуулсан хөрөнгийн нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

6.1. Төсвийн тухай хууль, тогтоомж анхан шатны нэгж, байгууллагад зөв хэрэгжих боломж бүрдэнэ.

6.2. Санхүүгийн ажилтнуудад цахим программ ашиглан мэдээллийг богино хугацаанд, үнэн зөв нэгтгэн гаргаснаар иргэдэд үйлчлэх санхүүгийн үйлчилгээ сайжирч, мэдээлэл ил тод, нээлттэй болох боломж бүрдэнэ.

6.3. Санхүү, бүртгэлийн ажилтны мэргэжлийн ур чадвар дээшилнэ.

6.4. Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайлангийн гаргалт сайжирна.

6.5. Санхүү бүртгэлийн үйл ажиллагаа сайжирснаар нийт байгууллагуудын орлого, ашиг нэмэгдэж, төсвийн үр дүн сайжирч, зарлага хэмнэгдэх боломж бүрдэнэ.

----- оОо -----